

Вэбэд суурилсан сургалтанд “сургалтын дизайн”-ыг ашиглах асуудалд

Л.Адилбат (докторант)

Улаанбаатар-Эрдэм Их сургууль

Оршил

- * Дэлхийн ихэнх улс орнуудад өрнөж буй даяршлын эриний хөдөлмөрийн зах зээл нь боловсролоос шинэ ур чадварыг суралцагчдад цаг хугацаа, орон зайн хамаарал багатайгаар эзэмшүүлэхийг шаардах боллоо.
- * Даяаршлын үеийн боловсролын зорилго нь сургалтын уян хатан тогтолцоо, “амьд” агуулгаар тодорхойгүй нөхцөл байдалд ажиллах, мэдлэгийг оновчтой хэрэглэх, мэдээлэл харилцааны технологийг ашиглах зэрэг ур чадваруудыг цаг хугацаа, орон зайн хамаарал багатайгаар суралцагчид эзэмшүүлэх, шинжлэх ухаан, технологийн мэдлэгтэй, оюунлаг иргэдийг бэлдэх явдал юм.

Технологид суурилсан сургалтыг нэвтрүүлэх, хөгжүүлэх бодлого зохицуулалтын орчин

- * Боловсролын тухай хуулийн 5.1.3- зүйл
“боловсрол эзэмшүүлэх арга хэлбэр, олон
хувилбартай нээлттэй байна “;
- * МУ-ын засгийн газрын хөтөлбөр:
 - * “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр ,
 - * “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр” ;

Технологид суурилсан сургалтыг нэвтрүүлэх, хөгжүүлэх бодлого зохицуулалтын орчин

- * Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 12 дугаар сарын 19 өдрийн 450 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт,
- * **Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртлэх хугацаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл,**
- * “1.4. Бага, дунд боловсролын сурах бичиг гарын авлага сургалтын бусад материалын электрон хувилбар бүхий нэгдсэн санг бий болгох, вэбэд суурилсан зайн сургалтыг өргөнөөр нэвтрүүлэх” ,

Технологид суурилсан сургалтыг нэвтрүүлэх, хөгжүүлэх бодлого зохицуулалтын орчин

- * Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 06 сарын 05 өдрийн 183 дугаар тушаал,
 - * **Мэдээллийн технологийн талаар авах зарим арга хэмжээний тухай,**
 - * 12. Сургуулийнхаа интернет сүлжээний хурдыг сайжруулах, багш, оюутан, сурагчдын мэдээллийн технологийн мэдлэг, түүнийг ашиглах ур чадвар, интернет сүлжээний ашиглалтыг сайжруулах, компьютер, дагалдах хэрэгсэл, програм хангамжийн тоо, чанарыг сайжруулахад анхаарч ажиллахыг бүх шатны сургуулиудын захирлуудад үүрэг болгосугай” гэжээ.

Монгол улсын бага, дунд, их дээд сургуулиудад хийгдэж буй ажлууд

- * Монгол улсын бага, дунд, их дээд сургуулиуд нь цахим сургууль, электрон сургалтын төвүүдийг байгуулах дүрэм журам боловсруулан сургалтын олон хэлбэрүүдийг ашиглан үйл ажиллагаагаа явуулж байна.
- * ШУТИС-ийн Эрдмийн Зөвлөлийн 2007 оны 05 сарын 03-ны өдрийн хурлаар ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭЛЕКТРОН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР –ийг хэлэлцэж баталсан байна.
- * ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР-тэй юм.
- * Эдгээр сургуулиуд хөтөлбөрийн зорилгоо сургалт, судалгааны ажилд чанарын ахиц гаргаж, **Нээлттэй Их Сургууль** болон хөгжихөд оршино гэж тодорхойлжээ.

Монгол улсын бага, дунд, их дээд сургуулиудад хийгдэж буй ажлууд

- * Ерөнхий боловсролын цахим удирдлагын
 - * **E-school** системийг 84, 13, 1-р сургуулиуд,
- * Их дээд сургуулийн удирдлагын мэдээллийн
 - * **UNIMIS** системийг 10 сургууль,
 - * **UNIFACE** системийг 14 их дээд сургууль, коллеж ашиглаж байна.

Вэбэд суурилсан сургалт

- * Вэбэд суурилсан сургалт нь дуу, дүрс шууд дамжуулах, имэйл, мэйлинг лист, чат, богино мэдээ, видео хурал, хэлэлцүүлэг зэрэг интернэтийн хялбар, хүртээмжтэй хэлбэрүүдийг хамтын сургалтандаа ашигладаг.
- * Вэбэд суурилсан сургалтын гол ололт нь интернэтийн сүлжээ ашиглан эргэх холбоог шуурхай хямд болгосон явдал юм.

Вэбэд суурилсан сургалт

* Давуу тал

- * Бүх төрлийн медиаг ашиглаж болно.
- * Интерактив харилцааны боломжит бүх сувгийг сонгон ашиглаж болно.
- * Мултимедиа ВСС-ыг суралцагчид олон янз хэлбэртэй, сэдэл идэвх төрүүлсэн байдлаар хүлээн авах нь элбэг.
- * Интернет дэх бусад эх үүсвэр рүү шууд холбож өгөх боломжтой.

* Сул тал

- * Хийхэд заримдаа маш ярвигтай.
- * Удаан эсвэл найдваргүй интернет холболттой газар тийм зохимжтой биш.
- * Шинэчлэхэд ялангуяа мултимедиа элемент олон орсон бол ярвигтай, өртөг ихтэй байдаг.

Сургалтын дизайн

- * Вэбэд суурилсан сургалтыг амжилттай явуулахын тулд мэдлэгийн бүтцүүдийг танилцуулж, дадлага хийх боломжоор зайлшгүй хангахын зэрэгцээ зөв удирдах ёстой. Дээрх хандлагыг сургалт зохион байгуулахдаа зөв ашиглах үйлдлийг судалдаг шинжлэх ухааныг сургалтын дизайн (Instructional design) гэнэ. Хамгийн энгийнээр тодорхойлбол, сургалтын материал, сургалтыг сонирхолтой, нөлөөтэй, үр дүнтэй болгодог сурган хүмүүжүүлэх хэрэглүүрийг сургалтын дизайн гэнэ.

Сургалтын дизайн

- * Сургалтын дизайны үүднээс вэбэд суурилсан сургалтанд ашигладаг ерөнхий “ADDIE” загварыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.
- * *Analysis(Шинжилгээ)* – энэ шатанд юу заахыг тодорхойлно. Суралцагч болон сургалтын агуулгын шинжилгээг хийнэ. Гол зорилго нь суралцагчдын суралцах хэв маяг, хэрэгцээг тодорхойлох, сургалтын орчин, боломжит нөөцүүдийг зөв илрүүлэхэд оршино.
- * *Design(Төлөвлөлт)* – хэрхэн заахыг тодорхойлно. Энэ шатанд суралцагчийн сурах үйл явцыг онцгойлон авч үзэж, сурах хандлага, хүлээн авах мэдээллийн бүтэц, стандарт, шалгуур, хүрэх амжилтыг тодорхойлно.

Сургалтын дизайн

- * *Development* (Хөгжүүлэх)– Сургалтын бодит үйл явц, ашиглах хэрэгслүүдийг тодорхойлно. Сургалтын материал, стратеги, үйлдлүүд, зайлшгүй шаардлагатай нөөцүүдийг бэлтгэнэ.
- * *Implementation*(Нэвтрүүлэх)- сургалтанд ашиглах програм хангамж, хэрэглүүрийн үүсгэх байгуулах, сургалтын орчинд байршуулах үйлдэл хийгдэнэ.
- * *Evaluation*(Үнэлэх)- Суралцагчийн амжилт, сургалтын хэрэглэгдхүүний чанарын үнэлгээг гүйцэтгэнэ.
- * Эдгээр үе шатууд нятасралтгүй цикл байдалтай явагдана

Сургалтын дизайн

- * Электрон сургалтын нэг хэлбэр болох вэб технологид суурилсан сургалтанд компьютерийн техник, интранет, интернэтийн сүлжээ, програм мөн мэдээлэл хангамжийн хүртээмжийг анхаарахаас гадна сургалтын вэб боловсруулах арга зүйн нэг хэсэг болох сургалтын дизайныг судалж амьдралд нэвтрүүлэх нь нэн чухал юм.
- * Учир нь аливаа сургалтыг хамгийн үр дүнтэй, өгөөжтэй байлгахад сургалтын дизайны онол, практикийн гол зорилго оршдог.

Сургалтын дизайн

- * Гадаад орнуудын туршлагаас харахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашигласан сургалтыг зохион байгуулахдаа сургалтын дизайныг заавал хэрэглэж, улмаар энэ чиглэлийн мэргэжилтэн бэлтгэхийн зэрэгцээ багшилж байгаа боловсон хүчин, багшийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг “Сургалтын дизайн” хөтөлбөрт хамруулж байна.

Сургалтын дизайн

- * Манай орны хувьд э-сургалтын төлөвлөлт, онлайн сургалтанд багшлах аргазүй, онлайн сургалтын агуулга боловсруулалт гэсэн онлайн сургалтыг “Цахим мэдлэг кампус” төрийн бус байгууллагаас багш сонирхсон мэргэжилтнүүдэд зориулан явуулж байна


Судалгааны зорилго

- * Манай орны хувьд вэбэд суурилсан сургалт нь харьцангуй шинэ, хуримтлуулсан туршлага бага зэрэг шалтгаануудаас хамааран нь жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй байна.
- * Сургалтын энэ шинэ хэлбэрийг судалж нийтийн хүртээл болгосон бүтээл, гарын авлага, аргачлал харьцангуй хомс байна.
- * Вэбэд суурилсан сургалтыг хамгийн үр ашигтай, үр дүнтэй зохион байгуулахад чухал үүрэгтэй “сургалтын дизайн”-ны тухай ойлголтыг их, дээд сургуулийн багш нар хэр сайн мэддэг болох, вэбэд суурилсан сургалтанд ямар хүчин зүйлүүд хамгийн ихээр нөлөөлдөг болохыг илрүүлэхэд судалгааны зорилго оршино.

Судалгааны үр дүн


- * Бидний судалгаанд МУИС, ХИС, ШУТИС, “Улаанбаатар” дээд сургууль, “Энх-Орчлон” дээд сургуулийн нийт 80 багш хамрагдлаа.
- * Судалгаанд хамрагдсан багш нарын 22% нь байгалийн ухааны, 78 % нь нийгэм-хүмүүнлэгийн чиглэлийн хичээл заадаг бөгөөд ажилласан жилээр нь авч үзвэл 1-5 жил ажилласан багш 47%, 6-10 жил -22%, 10-15 жил -14%, 16-20 жил -9%, 20 –иос дээш жил ажиллаж байгаа багш 8-% ийг эзэлж байна.

Та “сургалтын дизайн” гэсэн ойлголтыг хэр сайн мэдэх вэ?




Таны бодлоор доорх тодорхойлолтуудын аль нь “сургалтын дизайн” гэсэн ойлголтыг хамгийн сайн тусгаж байна вэ? 2 хувилбарыг сонгоно уу.

- Сургалтын дизайн гэдэг нь сургалтын материалыг байлгах тухай мэдлэгийг сургалтын материалын төлөвлөх, боловсруулах, үнэлэх, хэрэглэхдээ системтэйгээр ашиглахыг хэлнэ.
- Сургалтын дизайн гэдэг нь хичээлийн агуулга, суралцагчдын онцлогийг тооцон үзэж хүлээгдэж буй мэдлэг чадварыг эзэмшүүлэхийн тулд хамгийн оновчтой сургалтын аргазүйг шийдэх үйл явцыг хэлнэ.
- Сургалтын дизайн гэдэг нь аливаа сургалтын технологийн салшгүй нэг хэсэг бөгөөд технологийн болон үйл ажиллагааны механизм тул түүний ачаар сургалтын үйл явцад сургалтын технологийг бодитоор хэрэгжүүлдэг юм.
- Сургалтын дизайн гэдэг нь суралцагчдад илүү үр өгөөжтэй, үр ашигтайгаар электрон сургалтын материалыг боловсруулах системтэй үйл ажиллагаа юм.




Таны бодлоор электрон сургалтын орчинд байруулсан материалыг бүрэн эзэмшихэд ямар хүчин зүйл хамгийн их нөлөөлөх вэ? 3-4 хувилбарыг сонгоно уу:



Та өөрийн ашигладаг электрон сургалтын материалын чанарыг хэрхэн үнэлэх вэ?


- Сайн, сургалт явуулах шаардлагад нийцсэн
- Боломжийн, нэмэлт материал болгон ашигладаг
- Боломжийн, мэдлэгийн түвшин тогтоохдоо ашигладаг
- хариулахад хүндрэлтэй байна
- ашигладаггүй



Дүгнэлт

Боловсролын салбарын өнөөгийн хөгжлийн үе шатанд вэбэд суурилсан сургалтыг амжилттай явуулахад чухал үүрэгтэй сургалтын дизайны онол, практикийн асуудлыг судлах, хэлэлцэх, ашиглах нь зайлшгүй байх асуудал болон урган гарч ирж байна.

- * Манай орны хувьд энэ талаарх судалгаа, сургалтын ажил эхлэлийн шинжтэй байна. Мөн судалгааны ажлын тайлан, сургалтын материал хомс, сургалт явуулж буй байгууллага цөөн байна.
- * Бидний өмнөх судалгааны үр дүнд вэбэд суурилсан сургалтыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага байна гэсэн дүгнэлт гарч байсан. Энэ удаагийн асуулгын дүнд вэбэд суурилсан сургалтын материалыг бэлтгэх, сургалт явуулахад нэн тэргүүнд сургалтын дизайны онол аргазүйн асуудлыг судлах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, шинэ боловсон хүчин бэлтгэх асуудал урган гарч байна.



* Анхаарал тавьсанд
баярлалаа.